246

# БНМАУ
# УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ТОГТООЛ

1991 оны 9 сарын 12 №271 Улаанбаатар хот

Сургууль, цэцэрлэг нээж ажиллуулах тухай

Зээлийн хөрөнгөөр барьж, ЗХУ-ын мэргэжилтэн ашиглаж байсан сургууль, цэцэрлэгийн барилга монголын талд шилжсэнийг үндэслэн Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

I.Хотын дүүргүүдэд шинээр нээгдэх цэцэрлэг, цэцэрлэг сургуулийн цогцолборт I6I, I62, Зөвлөлтийн I дүгээр сургуулийг 30 дугаар сургуулийн өргөтгөл болгон, 2 дугаар сургуулийн барилгад 20 дугаар дунд сургуулийг шилжүүлэн, 38 дугаар бага сургуулийг 20 дугаар сургуулийн байранд шилжүүлэн 8 жилийн сургууль болгон тус тус хичээллүүлж, сурч хүмүүжих хүүхдийн тоо, бүлэг, ажиллах цаг, нээх хугацааг хавсралтын ёсоор тогтоож ажиллуулахыг хотын Боловсролын газар /н.Чимэддорж/-т даалгасугай.

2.I6Iдүгээр цэцэрлэг, I62 дугаар цэцэрлэг, сургуулийн цогцолбор I0 жилийн 20, 8 жилийн 30, 38 дугаар сургуулийн төсвийг зохих журмын дагуу зохицуулж санхүүжүүлэхийг Санхүүгийн газар /н.Гончиг/, хүнсний материал болон холбогдох зардлыг нэмж хуваарилахыг үйлдвэр, үйлчилгээ хариуцсан дэд дарга Л.Жавзмаад тус тус даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА Л.ЭНЭБИШ

ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ц.БОЛДСАЙХАН

Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны I99I оны 271 дугаар тогтоолын хавсралт

| № | Сургууль, цэцэрлэгийн дугаар | Ажиллах цаг | Анги бүлэг | Хүүхдийн тоо | Барилгыг ашиглаж байсан байгууллага, одоо хаана байрлаадаг | Нээх хугацаа | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| I. | I6I дүгээр цэцэрлэг | 24/I2 | I0 | 200 | Архаг өвчтэй хүүхдийн сувиллын байр Октябрь районы нутаг, Баруун хүрээ Ш хороолол. | 06/УШ | |
| 2. | I62 дугаар цэцэрлэг, сургуулийн цогцолбор | 24/I2 | 6/2 | 2I0 | СОТ-2-оос шилжиж ирсэн хүүхдийн цэцэрлэг. Октябрь районы нутаг, Баруун хүрээ Ш хороолол. | 0I/УШ | I99I оны 5-р сарын 22-ны I34-р тогтоолын 4-р заалтыг биелүүлнэ. |
| 3. | 20 дугаар сургууль | суудал I240 | 26 | I600 | Төмөр замын Зөвлөлтийн 2-р сургуулийн байр, Төмөр зам хороолол | 0I/IX | 20 дугаар сургуулийг хичээллүүлнэ. |
| 4. | 38 дугаар сургууль | суудал 720 | 20 | 800 | 20 дугаар сургуулийн хуучин байранд Октябрь районд | I0/IX | 38-р сургуулийг 20-р сургуулийн хуучин байранд 8 жилийн сургууль болгож оруулна. |
| 5. | 30 дугаар сургуулийн өргөтгөл | суудал 440 | | 750 | Зөвлөлтийн I дүгээр сургуулийн байр Найрамдал районд | 0I/IX | 30-р сургуулийн 2-р байр /өргөтгөл/ болгож ашиглана. |